

2009 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

Эрхэм Хамтрагч Танаа,

Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилэхийн ялдамд, АНУ-ын Азийн сангийн хариуцлагатай уул уурхай, байгаль орчны хяналтын хөтөлбөрийн хүрээнд Нидерландын Засгийн газрын санхүүжилтээр 3 жилийн турш амжилттай хэрэгжүүлсэн “Ирээдүйгээ Баталгаажуулах нь” төсөл ирэх сард дуусч байгааг мэдэгдэж байна. Уг төслийн хүрээнд:

- хариуцлагатай уул уурхайн төлөө олон талт хамтын ажиллагааны механизмыг бий болгох;
- байгаль орчны хяналтад орон нутгийн иргэдийг татан оролцуулах;
- байгаль орчны хамгаалалтыг хөхиүлэн дэмжих;
- усны чанарын хяналтын шинэ аргуудыг нэвтрүүлэх;
- улмаар хөдөө орон нутагт сургуулийн сурагчид болон нутгийн иргэдийг сургалтанд хамруулсан зэрэг олон арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн билээ.

“Ирээдүйгээ Баталгаажуулах нь” төслийг амжилттай хэрэгжүүлэхэд тус Сантай хамтран ажиллагч Та бүхний дэмжлэг, оруулсан хувь нэмрийг үнэлж баршгүй. Энэ дашрамд, Та бүхэнд гүн талархал илэрхийлэхийн зэрэгцээ цаашид хамтын ажиллагаагаа үргэлжлүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Энэ сарын 30-ны өдрөөр уг төслийн удирдагч Ребека Дарлинг болон холбогдох ажилтнууд тус Сан дахь ажлаа дуусгавар болгож байгаа билээ. Бид тэдний цаашдын ажил үйлсэд хамгийн сайн сайхныг хүсэн ерөөж байна.

Хэдийгээр төслийн хугацаа дуусч байгаа боловч АНУ-ын Азийн сан нь Монгол Улсад шударга ёс, хариуцлагын тогтолцоо, ил тод байдлыг бэхжүүлэхийн төлөө хамтран ажиллагч болохын хувьд, цаашид хариуцлагатай уул уурхай, байгаль орчны хяналтын тогтолцоог хөгжүүлэх ажилд гар бие оролцох болно.

Хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл манай general@asiafound.mn цахим хаягаар болон 330-524 дугаараар хандана уу.

Хүндэтгэсэн,

Мелони К. Линдберг
АНУ-ын Азийн Сангийн
Суурин Төлөөлөгч